



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Сар шинийн баярын өдрүүдэд нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах, хариуцлагатай эргүүл, жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын дүрмийн 2.5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүр, автомашинуудын хуваарийг нэгдүгээр, тээвэр зохицуулагч нарын хуваарийг хоёрдугаар, шинийн 1, 2, 3 буюу 02 дугаар сарын 27, 28-ны өдрүүд, 03 дугаар сарын 01-ний өдөр үйлчлэх тээврийн хэрэгслийн тоо, төлөвлөлтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын тусгай графикийг боловсруулан нэгдсэн даалгаварт тусган ажиллахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, баярын өдрүүдэд ажилласан автомашины шатахууны зардлыг гүйцэтгэлээр тооцож, хариуцлагатай эргүүл, жижүүрээр ажилласан албан хаагчдыг биеэр нөхөн амрахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т,


3. Баярын өдрүүдэд үйлчилгээний хэвийн, тогтвортой, шуурхай байдлыг хангаж ажиллах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд дээр хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарь гаргуулж мэдээ, тайланг авч нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, иргэд үйлчлүүлэгчдийн санал гомдолгүй, зам, тээврийн осол зөрчилгүй, соёлтой үйлчлэх талаар нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтарсан бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /С.Нямдорж/-т,

4. Сар шинийн баярын өдрүүдэд Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн хэвийн ажиллагааг хангаж баярын болон амралтын өдрүүдийн нэгдсэн тайлан мэдээг 2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр гаргаж ирүүлэх,

хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарь гаргаж ажиллахыг Улаанбаатар смарт карт ХХК /Юн Жүн И/-д,

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНБААТАР

